



ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ «ЖЕНКО ТУР БЮРО» ХК

“Женко тур бюро” Хувьцаат Компани 1997 онд байгуулагдсан бөгөөд үүсгэн байгуулагдсанаас хойш аялал жуулчлалын чиглэлээр дагнан үйл ажиллагаа явуулж байна.

Компани нь байгуулагдсан цагаасаа хойш жил болгон тайлан тэнцлээ гаргаж аудитын байгууллагаар баталгаажуулан, татвар, нийгмийн даатгалын ямар нэгэн зөрчилгүй үр ашигтай ажиллаж ирсэн бөгөөд хуулийн болон хөрөнгө оруулагч, ажиллагсдын өмнө хүлээсэн үүргээ ямагт биелүүлэн ажиллаж байгаагийн үр дүнд Монгол Улсын аялал жуулчлалын салбарт өөрийн гэсэн байр сууриа эзэлсэн компани болоод байна.

Компанийн ихэнх ажилчид манай улсын аялал жуулчлалын анхны компаниудын нэг болох “Баянгол Зочид буудал” ХК-д ажиллаж байсан, дадлага туршлагатай, харилцааны өндөр соёлтой, аялал жуулчлалын талаар мэргэшсэн ажилтнууд байна. Шинэ төслүүдэд тохирох чиглэлийн нарийн мэргэжлийн ажилтнуудыг сонгон шалгаруулан авч ажиллуулж байгаа бөгөөд төслийн явцад компанийн ажиллагсдын тоо 150–200-д хүрнэ.

Компани нь 2005 оноос нийт 10 тэрбум төгрөгийн өртөгтэй гурван салбар төсөл бүхий томоохон төслийг санхүүжүүлэн хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд энэхүү төслийн санхүүжилтын ажлын хүрээнд нийт 10 тэрбум төгрөгийн үнэ бүхий энгийн хувьцааг олон нийтэд санал болгон шинээр гаргаад байна.

Төслийн хүрээнд дараахь 3 салбар төслийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- “Чингисийн хөшөө” цогцолбор
- “13-р зуун” үндэсний парк цогцолбор
- “SPA” зочид буудал, гольфын иж бүрэн цогцолбор

Төслийн талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг дараахь бүлгүүдээс хүлээн авч танилцуулна уу.